



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/193

Улаанбаатар хот

**Сувилалын цэцэрлэг яслийн 10
дугаар цогцолборын данс бүртгэлээс
тээврийн хэрэгсэл хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/172 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Өмчийн харилцааны газраас 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан нээлттэй дуудлагын худалдаагаар худалдсан 833,333.0 /найман зуун гучин гурван мянга гурван зуун гучин гурван/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Мицибуши Делика маркийн 25-01 УНЕ улсын дугаартай тээврийн хэрэгслийг данс бүртгэлээсээ хасахыг Сувилалын цэцэрлэг яслийн 10 дугаар цогцолбор /Г.Буянжаргал/-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Сувилалын цэцэрлэг яслийн 10 дугаар цогцолбор /Г.Буянжаргал/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /Н.Раднаасэд/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ